

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/125/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2021он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2724

Цахим хаяг: ganulzii.b@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ш.Нарантуяа

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Гэрэлт хөхийн тэнцвэр  
Аудит” ХХК

Утас: 9611-2118 Цахим хаяг: Gerelt.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
АЗД	Аймгийн засаг дарга
АИТХТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	16
3.1. Ерөнхий зүйл.....	16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	17
3.4. Материаллаг байдал .....	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа: .....	<u>18</u>
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил: .....	18
Аудитын зөвлөмж:.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	19
4. Менежментийн захидал .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Дэд. ос. дт № 16/153

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ГАЗРЫН ДАРГА Ж.НАРАНБОЛД ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>87,803,621.85</b>	<b>46,053,890.49</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,200,000.00	4,752,952.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,200,000.00	4,752,952.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,200,000.00	4,752,952.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,200,000.00	4,752,952.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,956,846.40	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	648,020.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	4,308,826.40	-
3351	Байгууллагаас авах авлага	1,368,826.40	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,940,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	78,646,775.45	41,300,938.49
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	48,368,670.63	6,984,664.27
35110	Тусгай зориулалттай материал	48,368,670.63	6,984,664.27
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,278,104.82	27,185,274.22
35410	Бичиг хэргийн материал	1,417,334.00	1,314,244.00
35420	Аж ахуйн материал	22,277,770.82	22,501,430.22
35430	Сэлбэг хэрэгсэл	570,300.00	2,818,100.00
35440	Түлш, шатах тослох материал	12,700.00	551,500.00
35600	Мал амьтад	6,000,000.00	7,131,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>206,857,591.63</b>	<b>274,803,233.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	206,857,591.63	274,803,233.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	139,340,591.71	207,396,233.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	128,503,615.50	149,744,234.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,842,488.24)	(25,684,976.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,300,000.00	89,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,300,000.00)	(47,193,750.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,211,723.09	38,562,569.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,592,200.76)	(26,469,312.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,004,967.80	12,935,967.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,162,225.68)	(7,192,167.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,725,374.20	43,610,383.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,508,174.20)	(20,116,715.15)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	67,516,999.92	67,406,999.84
39301	Програм хангамж	5,908,145.00	7,008,145.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,143,145.08)	(2,353,145.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	62,752,000.00	62,752,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>294,661,213.48</b>	<b>320,857,123.84</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>294,661,213.48</b>	<b>320,857,123.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	294,661,213.48	320,857,123.84

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	829,485,493.11	829,485,493.11
51101	Өмч: - төрийн	829,485,493.11	829,485,493.11
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(619,307,144.60)	(593,111,234.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	86,025,169.19	(619,307,144.60)
51220	Тайлант үеийн үр дүн	(705,332,313.79)	26,195,910.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,482,864.97	84,482,864.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>294,661,213.48</u></b>	<b><u>320,857,123.84</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>372,512,122.07</b>	<b>485,239,223.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,800,919.07</b>	<b>78,774,003.65</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,800,919.07	78,774,003.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,800,919.07	78,774,003.65
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,058,800.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,940,000.00	-
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,860,919.07	74,715,203.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>361,711,203.00</b>	<b>406,465,220.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	257,871,800.00	397,900,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	257,871,800.00	397,900,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,839,403.00	8,564,620.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,042,520.00	648,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,796,883.00	7,916,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>399,323,132.60</b>	<b>459,043,313.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>399,323,132.60</b>	<b>459,043,313.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,240,409.98	428,472,132.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	143,553,199.20	183,593,111.00
210101	Үндсэн цалин	143,553,199.20	144,094,345.03
210102	Нэмэгдэл	-	31,002,698.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,496,067.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,697,003.68	24,777,600.00
210201	Тэтгэврийн даатгал	18,697,003.68	17,436,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,835,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,468,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,670,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,321,406.60	10,046,502.55
210301	Гэрэл, цахилгаан	1,666,939.00	1,140,472.55
210302	Түлш, халаалт	8,039,523.60	8,340,978.00
210303	Цэвэр, бохир ус	614,944.00	565,052.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,795,028.00	29,452,760.23
210401	Бичиг хэрэг	1,644,600.00	2,230,740.00

**Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	8,870,123.00	5,884,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	881,498.00	2,612,010.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	375,807.00	7,336,404.15
210408	Бараа материал акталсны зардал	879,000.00	11,245,306.08
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,050,000.00	-
210502	Хоол, хүнс	1,850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,976,290.51	1,192,002.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	81,000.00	-
210604	Урсгал засвар	5,895,290.51	1,192,002.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,101,300.00	2,760,300.00
210702	Дотоод албан томилолт	8,101,300.00	2,760,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	113,693,281.18	136,822,741.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,027,053.18	134,310,943.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,187,948.00	1,616,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,280.00	99,849.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57,052,900.81	39,827,115.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	5,154,749.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,340,754.00	295,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,212,146.81	34,377,366.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,082,722.62	30,571,180.95
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21,174,308.00	22,364,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	336,794.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,900,259.00	21,484,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,937,255.00	880,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5,908,414.62	8,207,080.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,908,414.62	7,777,060.95
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		430,020.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(26,811,010.53)</b>	<b>26,195,910.36</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	678,521,303.26	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	678,521,303.26	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(678,521,303.26)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(705,332,313.79)</b>	<b>26,195,910.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан  
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>362,652,403.00</b>	<b>413,464,020.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>500,000.00</b>	<b>6,998,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	500,000.00	6,998,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	500,000.00	6,998,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	4,058,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,940,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>362,152,403.00</b>	<b>406,465,220.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	257,871,800.00	397,900,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	257,871,800.00	397,900,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	104,280,603.00	8,564,620.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,483,720.00	648,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,796,883.00	7,916,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>341,864,308.00</b>	<b>411,811,068.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>341,864,308.00</b>	<b>411,811,068.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>314,313,565.38</b>	<b>380,739,887.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	143,553,199.20	183,495,522.00
210101	Үндсэн цалин	110,795,099.20	143,996,756.03
210102	Нэмэгдэл	26,221,600.00	31,002,698.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,536,500.00	8,496,067.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,944,100.00	24,777,600.00
210201	Тэтгэврийн даатгал	12,202,000.00	17,436,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,435,500.00	1,835,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,148,400.00	1,468,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	287,100.00	367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,100.00	3,670,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,338,908.00	8,775,265.15
210301	Гэрэл, цахилгаан	1,533,108.00	1,140,472.55
210302	Түлш, халаалт	8,951,300.00	7,069,740.60
210303	Цэвэр, бохир ус	854,500.00	565,052.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,350,230.00	11,471,015.00

**Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	955,300.00	2,353,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,814,400.00	4,692,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	923,400.00	2,735,830.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513,130.00	1,544,635.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,082,800.00</b>	<b>4,080,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,082,800.00	4,080,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,675,880.00</b>	<b>5,262,254.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,025,000.00	225,000.00
210604	Урсгал засвар	1,650,880.00	5,037,254.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,295,300.00</b>	<b>2,760,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,295,300.00	2,760,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>119,563,875.18</b>	<b>139,122,930.90</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,897,647.18	136,611,133.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,187,948.00	1,616,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,280.00	99,849.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,509,273.00</b>	<b>995,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,009,273.00	295,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,550,742.62</b>	<b>31,071,180.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,994,308.00</b>	<b>22,864,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,900,259.00	21,484,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,094,049.00	1,380,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,556,434.62</b>	<b>8,207,080.95</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,908,414.62	7,777,060.95
213304	Хөрөнгийн	648,020.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		430,020.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>20,788,095.00</u></b>	<b><u>1,652,952.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>11,798,000.00</u></b>	<b><u>1,100,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>11,798,000.00</u></b>	<b><u>1,100,000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b><u>11,798,000.00</u></b>	<b><u>1,100,000.00</u></b>
223001	Бусад хөрөнгө	11,798,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,100,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(11,798,000.00)</u></b>	<b><u>(1,100,000.00)</u></b>

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	8,990,095.00	552,952.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	4,200,000.00	4,200,000.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	4,752,952.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>				0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	829,485,493.11	84,482,864.97	-619,307,144.60	0.00	294,661,213.48
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00		0.00	0.00
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>829,485,493.11</b>	<b>84,482,864.97</b>	<b>-619,307,144.60</b>	<b>0.00</b>	294,661,213.48
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>829,485,493.11</b>	<b>84,482,864.97</b>	<b>-619,307,144.60</b>	<b>0.00</b>	294,661,213.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>829,485,493.11</b>	<b>84,482,864.97</b>	<b>-619,307,144.60</b>	<b>0.00</b>	294,661,213.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	26,195,910.36	0.00	26,195,910.36
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>829,485,493.11</b>	<b>84,482,864.97</b>	<b>-593,111,234.24</b>	<b>0.00</b>	320,857,123.84

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	397,900,600.00	397,122,339.05
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	397,900,600.00	397,122,339.05
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	375,215,500.00	374,438,239.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	183,536,300.00	183,495,522.00
210101	Үндсэн цалин	138,176,100.00	143,996,756.03
210102	Нэмэгдэл	36,823,700.00	31,002,698.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,536,500.00	8,496,067.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,777,600.00	24,777,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,436,000.00	17,436,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,835,400.00	1,835,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,468,300.00	1,468,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	367,100.00	367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,670,800.00	3,670,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,899,700.00	8,775,265.15
210301	Гэрэл, цахилгаан	1,250,800.00	1,140,472.55
210302	Түлш, халаалт	7,094,400.00	7,069,740.60
210303	Цэвэр, бохир ус	554,500.00	565,052.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,310,000.00	11,309,415.00
210401	Бичиг хэрэг	2,192,600.00	2,192,350.00
210402	Тээвэр, шатахуун	4,692,600.00	4,692,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,736,100.00	2,735,830.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,544,700.00	1,544,635.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,081,800.00	4,080,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,081,800.00	4,080,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,262,800.00	5,262,254.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	225,000.00	225,000.00
210604	Урсгал засвар	5,037,800.00	5,037,254.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,879,300.00	2,760,300.00
210702	Дотоод албан томилолт	2,879,300.00	2,760,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	133,278,000.00	132,982,882.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,666,100.00	129,371,085.00

**Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,617,000.00	1,616,948.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,900.00	99,849.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,190,000.00</b>	<b>995,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,000.00	295,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,685,100.00</b>	<b>22,684,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,685,100.00</b>	<b>22,684,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,484,100.00	21,484,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,201,000.00	1,200,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>397,900,600.00</b>	<b>404,899,400.00</b>
<b>1320</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>397,900,600.00</b>	<b>397,900,600.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	397,900,600.00	390,123,539.05
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		6,998,800.00

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,714,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,714,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,714,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	161,600.00
210401	Бичиг хэрэг	161,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,553,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,553,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,144,620.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,144,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	648,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,496,600.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ж.Наранболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, аудитор Ш.Нарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих хүнс, хөдөө ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг хангах үйлдвэрлэл үйлчилгээг нэвтрүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлж иргэдийг экологийн цэвэр, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, мал эрүүлжүүлэх замаар хүн амын хүнсний баталгаат байдлыг хангаж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэхэд оршино гэсэн эрхэм зорилго дор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, удмын сан эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах
- Хүнсний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, усжуулах арга хэмжээг өргөжүүлэн, уст цэгийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулах
- Хөрс хамгаалал, тариалангийн газар ашиглалтыг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/87 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална” (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 375,215.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,752.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,195.9 мянган төгрөгөөр буюу 8,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	4,200.0	4,752.9	552.9
Авлага	4,956.8	0	-4,956.8
Урьдчилгаа			-
Бараа материал	78,646.8	41,300.9	-37,345.8
Үндсэн хөрөнгө	206,857.6	274803.2	67,945.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>294,661.2</b>	<b>320,857.1</b>	<b>26,195.9</b>
Өр төлбөр			-
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	294,661.2	320,857.1	26,195.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>294,661.2</b>	<b>320,857.1</b>	<b>26,195.9</b>

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Оны эцэст цалингийн урьдчилгааны үлдэгдэлгүй байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэл 41,300.9 мянган төгрөг болж 37,345.8 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд 36,106.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал шилжүүлсэнээс нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 67,945.6 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 42,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 37082.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 21,240.6 мянган төгрөгийн барилга байгууламж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дансанд 2020 онд ямар нэгэн материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй байна. Мөн 2020 онд өглөг, авлагагүй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 829485.5 мянган төгрөг болж 18,146.9 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 26,195.9 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

2020 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 14,0 хувиар буурсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,219,135.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,219,135.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 821,234.5 мянган төгрөгөөр бууруулж, 397,900.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвийн санхүүжилтээр 397,900.6 мянган төгрөг, өөрийн орлого 6998.8 мянган төгрөг нийт 404,899.4 мянган төгрөг төвлөрснөөс 397,122.3 мянган төгрөг зарцуулж 7,777.1 мянган төгрөг эргэн төвлөрүүлсэн байна.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 648.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,496.6 мянга, нийт 7,144.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 161.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 6,553.0 мянга, нийт 6,714.6 мянган төгрөгийг зарцуулж, 430.0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 оны 149 мэдээллийг бүрэн мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан байна.

Тус онд шилэн дансанд мэдээлэх 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Дорноговь аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газарт итгэл үзүүлж ажилласан байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 70,965.7 мянган төгрөгийн зөрчилд 70,965.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, УСНББОУС, НБББББ-ийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчил илрээгүй.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 70,965.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын эргэлтийн болон үндсэн хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байна.

Мөн УСНББОУС-ын дагуу тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, цалингийн зардалд шууд бичилт хийгдсэн байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

#### **4.1.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 16 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

#### **4.1.2 Эрсдэл:**

Төсвийн байгууллагын төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо алдагдах

#### **4.1.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хуульд заасан зайлшгүй байршуулах мэдээллийг хугацаанд нь чанартай байршуулж байх

#### **4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид анхаарч ажиллана.

Дорноговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021.02.25			ДГА-2021/120/СТА-ТШЗ
Шалгагдагч байгууллагын нэр:	<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллийг 148 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр байршуулсан байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Тэгшжаргал, У.Буянбат
НИЙТ ДҮН					